

Бихумарын Өмирбек¹

¹Монгол Алтайн хадны зургийн цогцолборын
хамгаалалтын захиргаа, Баян-Өлгий, Монгол.

Их Ойгорын хадны зураг

Товчлол. Тус өгүүлэлд Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрээс шинээр илэрсэн Их Ойгор хэмээх газрын хадны зургийн талаар өгүүлэх болно. Их Ойгорын хадны зураг нь хэдийгээр цөөн тооны боловч эрдэм шинжилгээ, судалгааны өндөр ач холбогдолтой дурсгал юм. Энд нийт 300 орчим зураг дүрс байна гэж тооцоолж байна. Дурсгалт газарт дүрслэгдсэн дүрүүд аргаль, үхэр, буга согоо, янгир, хүн, хуягт бөө, тодорхойгүй дүрслэл зэрэг бөгөөд ихэнх нь түрүү хүрлийн буюу хэмцэгийн түүхэнд холбогдож байна. Их Ойгорын хадны зурагт нэг дор олноороо зурагдсан хуягт бөө нарын дүрслэл түрүү хүрлийн үеийн түүхийг тодруулахад маш их үнэ цэнэтэй дурсгал гэж үздэг. Тиймээс бид энэхүү дурсгалт газрын хадны зургийг хуягт бөө нараар төлөөлүүлэн эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж байна. Их Ойгорын хадны зургийг наран эвэр, голд шахсан налуувтар ханан хаданд сийлсэн ба түүхийн урт хугацаанд холгорч элэгдснээс гадна хүний буруутай үйл ажиллагаанд ихээр өртжээ. Цаашид нэн яаралтай хамгаалах шаардлагатай байна. Хүмүүс дээрээс нь нэр усаа ихээр бичиж гэмтээсэн нь илт харагдаж байна. Энэхүү өгүүлэл нь Их Ойгорын хадны зургийг олон нийтэд сурталчлан таниулахаас гадна, хадгалалт хамгаалалтанд авах эхний алхмыг бүрдүүлж байна.

Түлхүүр үг. Хэмцэг, Их Ойгор, Их Ойгорын хадны зураг, түрүү хүрлийн үе, хуягт бөө, ороомог, үхэр, нум, толгой, эвэр шүтлэг

Umirbek Bikhumar¹

¹Administration of protection of the petroglyphic
complex of Mongolian Altai. Bayan-Ulgii, Mongolia

Petroglyphs of the Ikh Oigor

Abstract. It is presented about the newly discovered rock paintings of Ikh Oigor in the territory of the 1st bagh of Ulaankhus Sum, Bayan-Olgii province in this article. The rock paintings of Ikh Oigor are a historical site which is considered to have high importance in scientific research despite their small amount. It is estimated that there are about 300 images in total; approximately 150 images in the site and more than 150 images above the monument. The figures depicted here are images of argali, cattle, deer, ibex, man, shaman in armor, and most of them are related to early bronze or medieval history. The images of armored shamans depicted in large numbers in the rock paintings of Ikh Oigor are considered to be very valuable monuments to study the history of the Early Bronze Age. Therefore, we are introducing the rock paintings of this monument into academic circulation by representing them as shamans in armor. Ikh Oigor's rock paintings were carved into the rocks against the sunshine and along the river. They have been damaged during the historical long period besides being affected by human's wrong activities. It is urgent to protect the site and prevent future damages. People keep writing their names on it. This article is the first step in the preservation and protection of the rock paintings of Ikh Oigor.

Keywords. Khemtseg, Ikh Oigor, Petroglyphs of the Ikh Oigor, early bronze age, huyagt boo, oroomog, cow, bow, head, horn workshop

Удиртгал

Монгол Алтайн баруун хэсэг Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт орших Алтай Таван Богдын зүүн суг ертөнцийн зүг чигээр бол зүүн хойд талаас зүүн урагш сунан тогтсон өндөр уулсын гүн хавцлаар урсан уруудсан олон жижиг булаг чандаас эх авсан голыг Их Ойгорын гол

хэмээн нэрлэнэ. Их Ойгорын голын зүүн талаас Дунд Ойгорын гол, Бага Ойгорын гол нийлж урсана. Их Ойгорын гол ойролцоогоор 110 км орчим урсаж Хөх хөтөл багийн төв орох бөгөөд түүнээс доошоо урсах хэсгийг Согогийн гол хэмээн нэрлэнэ. Их Ойгорын гол Согогийн голд нийлж 155 км урсаж Ховд голын зүүн бөөрнөөс ирж сутгадаг.

Их Ойгорын дунд бие Их Ойгор голд шахаж тогтсон налуувтар хадтай булан тохойд нэг дор нэлээд хадны зураг сийлжээ. Налуувтар ханан хад ойролцоогоор 8 м х 5 м хэмжээтэй бөгөөд хадны зураг нь наранд гандсан, холторч гэмтсэн, хадны зургийн дээрээс казах иргэд өөрсдийн нэрсээ бичиж нэлээд гэмтээсэн байна. Зурагтай хадны ойролцоо өөр ямар нэгэн түүхэн дурсгал, хадны зураг алга байна. Харин дурсгалт газраас дээшээ 300 орчим метрт тархай бутархай цөөн зураг илэрчээ. Эдгээр зургууд нь голдуу янгир, аргаль буга зэрэг түгээмэл дүрслэлүүд байна. Бид Их Ойгорын хадны зургийг ерөнхийд нь багцаалж 200-300 орчим зураг байна гэж үзлээ.

Энэхүү хадны зургийг анх 2020 онд доктор Я.Цэрэндагва, С.Далантай нар “Нэн эртний хүний үл мөрийг Алтай Таван Богдоос хайх цогц судалгаа” [Цэрэндагва, Далантай, 2020] төслийн хээрийн судалгааны явцад олж харсан бөгөөд доктор Я.Цэрэндагва шинээр илрүүлсэн хадны зургийн хэд хэдэн дүрслэлийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулжээ. Миний бие дээрх судлаачдын нийтлүүлсэн зургийг нэхэн сурвалжилж 2020 оны намар Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны ажлын шугамаар зорин очиж солбицол, гар хуулгыг авч баримтжуулсан ба 2021 онд Дэлхийн өв-Монгол Алтайн хадны зураг бүтээлд анх илрүүлсэн судлаачдын зөвшөөрлөөр зургийг нийтлүүлсэн юм [Өмирбек нар, 2021:49].

Их Ойгорын хадны зургийн Ойгор голд шахаж тогтсон налуувтар ханан хаданд нийтдээ 150 гаруй дүрс сийлсэн бөгөөд аргаль, янгир, үхэр, буга, согоо, хуягт бөө, тодорхойгүй дүрслэлүүдийг урласан байна. Хэдийгээр цөөн дүрслэлтэй боловч дурсгалт газрын хадны зургийн гол дүр “хуягт бөө” -г нэг дор олноороо дүрсэлсэн явдал юм. Энд нийтдээ 6 ширхэг хуягт бөөг дүрсэлжээ. Эдгээр дүрүүдийг тойруулж сийлсэн зургуудын ихэнх нь гол дүрд хамааралтай үхэр, буга, согоо, янгир, аргалийн дүрслэл байна. Хуягт бөө нарын он цагийн хамаарлыг эрдэмтэд НТӨ III-II мянган жил буюу НТӨ 2600-1800 оны хооронд зурагдсан гэж үзжээ [Төрбат, 2019: 5-16]. Бид энэхүү судалгааны өгүүлэлд Их Ойгорын хадны зургийн он цагийн хамаарлаас гадна археологийн адилтгал талаас нь харьцуулан судлахыг зорьсон юм. Учир нь энд зурагдсан зургуудын гол дүр болох хуягт бөө нарын талаар судлаачдын нэгдсэн нэг ойлголт байхгүй бөгөөд өөр өөрсдийн саналыг дэвшүүлсэн байдаг. Энэхүү хүн дүрст зохиомжийн гаднах төрхийг судлаачид “хонхон хүн”, “хонх хэлбэрийн хүн”, “шувуу хүн” [Кубарев, 2003: 46-61], “нөмрөгтэй хүн”, “нөмрөгтөн” [Төрбат, 2019: 5-16], “хуягт бөө”, “бөөгийн хуяг” [Өмирбек, 2019: 52-53] гэх зэргээр шинжлэх ухаанд оруулж он цагийн хамаарлыг тогтоохоос гадна зургийн

эздийг тодруулахыг зорьжээ. Доктор Ц.Төрбатын үзэж байгаагаар энэхүү дурсгал нь түрүү хүрлийн үеийн “Хэмцэг”- үүдийн түүхэнд холбогдох бөгөөд өвөрмөц соёлыг бүтээгчид байсан байна [Төрбат, 2019: 5-16].

Их Ойгорын хадны зураг дахь хүн дүрст дүрслэл, зохиомжийг миний бие хуягт бөө гэж нэрлэж байгаа бөгөөд түрүү хүрлийн үеийн бурхад, бөө нар гэж үзсэн. Тиймээс дэвшүүлсэн санаагаа бататгахын тулд ийм дүрслэлүүдийн судалгааг 2013 оноос хойш хийж нэлээд газрын хадны зургаас ижил төстэй дүрүүдийг олж харьцуулан судалж байна. Хуягт бөөгийн дүрслэл одоогоор Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Цагаан салаа-Бага Ойгорын хадны зураг, Цэнгэл сумын Харганатын хадны зураг, Сагсай сумын түрүү хүрлийн үеийн булшны хавтан, Улаанхус сумын Хар чулуут, Годон голын түрүү хүрлийн үеийн булшны хавтан, Буянт сумын Хойд Хөлцөөтийн хадны зургаас олж илрүүлээд байна [Өмирбек, 2013]. Хуягт бөө дүрсэлсэн хавтны зургийг одоогоос 100 гаруй жилийн өмнө Гране өөрийн судалгааны бүтээлд нийтлүүлж байжээ [Төрбат нар, 2019: 375-382]. Түүнээс хойш эдгээр дүрслэлийн талаар тусгайлан судалсан судалгаа гараагүй боловч хөрш орнууд БНХАУ-ын Шинжаань Уйгурын өөртөө засах орон, Бүгд найрамдах Казахстан улсын дорнод хэсгээс олдсон хүн чулуудын их биед дүрслэгдэснийг нийтлүүлж байжээ [Мөнхбаяр, 2010: 11].

Хэлэлцүүлэг

Хуягт бөөгийн дүрслэл дангаараа заримдаа зохиомж хэлбэрээр мөн зохиомж дунд зурагдсанаараа судалгааны өндөр ач холбогдолтой дурсгал билээ. Тиймээс бид Их Ойгорын хадны зургийг авч үзэхдээ хуягт бөөгийн дүрээр төлөөлүүлэн археологийн адилтгал, харьцуулалт хийв.

Хуягт бөө: Хадны зураг дахь хуягт бөө гэж нэрлэгдсэн түрүү хүрлийн үеийн дүрслэлийг хаданд сийлж урлахдаа олон янзаар дүрслэх боловч гаднах төрхөөр ижил төсөөтэй харагдахаар сийлсэн байдаг. Хэмжээний хувьд ч нэг их том биш бас жижгэвтэр биш дунд зэргийн байх ба 25x25 см, 15x15 см-ийн харьцаагаар хаданд сийлж дүрсэлсэн байна. Хуягт бөөг голдуу наран ээвэр ханан хад, чулуунд дүрслэхээс гадна дангаар нь мөн зохиомж дунд дүрслэнэ. Ингэхдээ босоо болон хавтгай орон зайд дүрсэлдэг нь сонирхол татаж байна. Энэ нь үхэл амьдралыг, газар тэнгэрийг хоршсон ойлголт болов уу. Хуягт бөөг сийлж урлахдаа энгийн бөгөөд чимэглэсэн өөрөөр хэлбэл хүний их биед сараачсан дүрслэл, үхэр, /бух, шар/ ороомог, бүс, дээл, унжлага, цацаг, толгой хэсэгт (антен ч гэмээр) өд сөд, эвэр

ургуулснаар сийлж дүрсэлсэн нь хуягт бөөгийн нууцад нэвтрэхэд сэжүүр болж өгдөг. Их Ойгорын хадны зурагт дүрслэгдсэн хуягт бөөгийн дүрслэл судалгааны өндөр ач холбогдолтой дурсгал болоод байна. Хуягт бөөгийн өмссөн хувцас хунар, эд юмсыг судалснаар түрүү хүрлийн “бөө” нар буюу бурхадууд байсныг улам тодруулах боломж бүрдүүлж байна. Их Ойгорын хуягт бөө нар Цагаан салаа-Бага Ойгор, Харганат, Колагаш, Годон гол, Хар чулуутын бөө нарын зурагтай ижил төстэй зурагджээ.

Толгой: Хэмцэгийн соёлын хуягт бөө нарын толгойг хадны зурагт дүрслэхдээ олон янзаар дүрсэлж иржээ. Тухайлбал, бөөрөнхий, тэгш дөрвөлжин, орой хэсгээр тэгш, гурвалжиндуу дүрслэх нь бий. Ингэхдээ данхар эвэртэй, антен ч гэмээр эгц босоо зураастай, заримд нь нэлээд олон эгц зураас татаж үзүүр хэсгээрээ цацаг ургуулжээ (Зураг-VIII). Энэ нь шувууны өд сөд бололтой. Хуягт бөө нарын толгойн өмсгөлийг үндсэндээ хоёр ангилж болохоор байна. Үүнд: Нэгдүгээрт эвэртэй, хоёрдугаарт, өд сөдтэй гэсэн үндсэн хоёр төрөл ажиглагдана. Хуягт бөө нарын толгойд дүрслэгдсэн эврийг “эвэрт дуудлага” уу, малгай юу гэдгийг тодруулах боломж байхгүй хэдий ч үхэр шүтлэг, хүч чадлын бэлгэдэлтэй холбоотой бололтой. Учир нь хэмцэгийн түүхэнд холбогдох өөр нэг гол дүрслэл болох “бөхчүүдийн дүр” юм [Цэвээндорж нар, 2010: 86]. Хойд Хөлцөөтийн хадны зурагт эвэр ургуулсан толгойтой бөхчүүд өөр хоорондоо тэмцэлдэж байгаа дүрслэлийг сийлсэн байдаг [Өмирбек, 2013]. Энд дүрслэгдсэн бөхчүүдийн дүрийг мөн үхрийн дүрслэлд нэг зохиомжинд оруулж сийсэн нь ямар нэгэн байдлаар үхэр шүтлэгтэй холбоотой болохыг харуулж байна. Иймд хуягт бөө нарын эвэр ургуулсан дүрслэл нь эхэндээ шүтлэг байснаа сүүлд хүч чадлын бэлгэдэл, үхэр /шар/ онгод тэнгэртэй хамааралтай болж хөгжсөн бололтой. Харин өд, сөд хадах уламжлал өнөөгийн бөө нарын дунд хэвээр хадгалагджээ. Энэхүү хуягт бөө нарын эвэр, өд сөдийг цаашид харьцуулан судлах шаардлагатай байна.

Үхэр: Түрүү хүрлийн үеийн хуягт бөө нарыг ямагт үхрийн дүрслэлтэй хамт сийлж урладаг нь судлаачдын анхаарлыг ихээр татсан байна. Тухайлбал, Ц.Төрбат энэхүү хүн дүрст бурхдыг заавал үхрийн дүрслэлтэй нэг дор зохиомжинд оруулж сийлж урлаж байсныг харьцуулан судалж байжээ [Төрбат, 2019: 5-16]. Түүнчлэн хуягт бөө нарын зарим дүрслэлд толгойд данхар эвэр, заримдаа эгц шулуун эвэр, хагас саран хэлбэрийн эвэртэй дүрсэлж байсан нь ямар нэгэн шүтлэгийн хэлбэр юм болов уу. Судлаачид үхэр шүтлэг, үхрийн эвэр шүтлэгийн талаар өмнө нь судалж байсан бөгөөд эртний хүмүүсийн дунд

үхэр маш чухал үүрэг гүйцэтгэж байсан, зарим овог аймгийн сүсэг бишрэл, оюун санаанд гүн шингэсэн байдаг [Өмирбек, 2011: 63-70]. Түрэг-монгол угсаатны олон овог аймгуудын дунд үхэр шүтлэгтэй холбоотой маш олон домог, яриа бий. Казахуудын дунд дэлхийг газар доорх “хөх өгиз” буюу хөх өнгийн шар өргөж байдаг. Нуруугаа амраахад газар хөтөлдөг, хөх шар газар дэлхийг эврээрээ өргөж байдаг гэнэ. Эврээ амраахын тулд толгойгоо сэгсрэхэд газар амардаг гэх зэргээр хуучлах бөгөөд энэ нь “шар” хүчтэй, хүч чадлын бэлгэдэл гэдгийг харуулдаг. Түүнчлэн казах бөө нарын онгод дотор “шар” онгод байдаг. Энэ нь мөн адилхан хүч сүр жавхланг харуулсан хүчтэй амьтан гэдгийг бэлгэдсэн байдаг. Тэгэхээр казахууд яагаад бух биш шарыг эрхэмлэн хүндэтгэж ирсэн бэ гэх асуулт ургана. Нүүдэлчид зассан үхрийг “шар” гэж нэрлэнэ. Шарыг нүүдэл суудал, ачлага уналгад өргөн хэрэглэнэ, маш хүчтэй байдаг. Тиймээс хүч чадлын бэлгэдэл шар хэмээн үздэг байсан нь хожмын казахуудад хадгалагдан үлджээ. Харин Монголчуудын хувьд “бух” хүч чадал, эрх мэдлийн бэлгэдэл гэж үздэг. Үүний тод жишээ баруун монголчуудын бух барилдаан, бух ноололдооныг нэрлэж болно. Дээрх хоёр үндэстнийг нийлүүлж байгаа үхэр шүтлэгийн гол сэжүүр түүний “эвэр” болж байгаа юм. Эртний нүүдэлчид эврийг эрх мэдэл, хүч чадлын бэлгэдэл гэж үзэж ирсэн [Өмирбек, 2011: 63-70]. Хүннү нарын эвэртэн, туурайтнууд, Их Монгол улсын үеийн МНТ-нд гардаг эвэртэй холбоотой домог, хууч яриа, монгол бөхийн үүсэл гарал, эврээрээ тулах гэх зэрэг олон жишээг дурдаж болно. Хэмцэгийн түүхэнд холбогдох хуягт бөө нарын дүрслэлд эвэр ургуулсан нь хүч чадлын бэлгэдлээс гадна ямар нэгэн үхэр шүтлэгтэй салшгүй холбоотой бололтой. Их Ойгорын хадны зурагт хоёр удаа хуягт бөөгийн их бие, хормой хэсэгт өөд өөдөөс нь харж, мөргөлдөхөөр зэхэж байгаа мэт, урт нарийхан сүлээ хондлой нуруу дагуулж эрчилсэн бух гэмээр үхрийн хос дүрслэлийг чадварлаг сийлж урласан байна. Үхрүүдийг эгц хажуунаас сийлсэн бөгөөд хоёр хөл, урт үзүүрээ цацагтай нарийхан сүүлийг салхинд хийсэн мэт дүрсэлжээ. Түүнээс гадна эврийг урагшаагаа ялимгүй муруйлттай сийлж урлахдаа нарийсгаж дүрсэлсэн байна (Зураг-I, II, VI). Ийм өөд өөдөөс нь тулсан хос үхэр хожмын хүннү нарын археологийн олдвороос нэлээд олдож байсан нь түрүү хүрлийн соёлын уламжлал байсан бололтой.

Хуягт бөө нарыг сийлэхдээ ойр орчим заримдаа нэг хаданд хамтад нь үхрийн дүрслэлийг сийлж байжээ. Цагаан салаа-Бага Ойгорын хадны зураг-21, Буянт сумын Хойд Хөлцөөтөд-1, Цэнгэл сумын Харганатын хадны зурагт-1 хуягт бөөгийн дэргэд үхэр, хос үхрийн дүрслэлийг хамтад нь сийлжээ. Энэ үзэгдэл Их Ойгорын хадны

зурагт мөн давтагдаж байгаа нь хуягт бөө нарыг бүтээгчид үхэр шүтлэгтэй байсан болов уу гэсэн таамгийг төрүүлнэ.

Ороомог: Их Ойгорын хадны зураг дахь хуягт бөөгийн хоёрыг цээжин хэсэгт хос эргүүлэг буюу ороомогтой дүрсэлсэн байна (Зураг-I,II). Судлаачдын үзэж байгаагаар ийм хэлбэрийн дүрслэл энолит неолитын үеэс уламжлагдсан бөгөөд одоогоор утгыг нь бүрэн тайлж амжаагүй л байна. Хөгжингүй, хожуу хүрлийн үеийн буган хөшөөний соёлд ч энэ дүрслэл байх бөгөөд судлаачид өөр өөрсдийнхөөр тайлбарлажээ [Өмирбек, 2019: 181]. Хуягт бөө нарын цээжинд байгаа хос эргүүлэг, ороомгийг “тэнгэрийн хуйлрал” гэж үзэж тайлбарлах нь илүү үнэнд ойр мэт санагдана. Эртний хүмүүс байгаль цаг уурын өөрчлөлт, тэнгэрт үүл хурж, салхи дэгдэж хуйлрал үүсгэх үзэгдлийг ажиглан, айх, эмээх, эрхшээлд орсноор нэгэн ёсны бөө мөргөлийн сүсэг бишрэлийн нэг хэлбэр бий болж, хожим дүрсийг ашигласан болохыг үгүйсгэхгүй. Энэ үзэгдэл ан амьтдын дунд ялангуяа цаа буга холын нүүдэл хийх, байгалийн гамшиг зуд зурхан хахир хүйтэн болохыг урдаас мэдэх үед дороо эргэлдэж эргүүлэг үүсгэдэг нь ямар нэгэн байдлаар далд холбоотой ч байж мэднэ. Хуягт бөө нарын цээжинд буй хуйлрал нь хоёр нь том, хоёр нь жижиг нийт дөрвөн хос зурагдсан байна (Зураг-I, II). Ороомгийг хуягт бөө нарын цээжин тус газарт нэлээд томоор дүрсэлсэн нь ямар учиртай болохыг эцэслэн тайлаагүй ч тэнгэрийн хуйлрал, бөө мөргөлд салшгүй холбоотой мэт санагдана. Ороомгийн судалгааг цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.

Нум: Хуягт бөө нарт дүрслэгддэг нэгэн төрлийн зэр зэвсгийг нум гэж үзэж байгаа. Энэ тухай Хэмцэгийн түүхэнд холбогдох хүн чулуудад тодорхой дүрслэгдсэн байдаг [Өмирбек, 2019: 220-223]. Түүнчлэн хэмцэг хүн чулуун хөшөөнд махир багаж, таяг, ташуур ч гэмээр дүрслэл байдаг. Ер нь эртний бөө нарын ташуур, таяг гарт барьж онгод улаачийг дуудах, бөөлөх үед ашиглаж байсан уламжлал одоо ч байна. Их Ойгорын хуягт бөө нарын бүслүүр хэсэгт хөндлөн зүүсэн нум хэлбэрийн дүрсийг цаашид судлах шаардлагатай байна (Зураг-I, II).

Дээл: Их Ойгорын хуягт бөөгийн гадна хэлбэрийг ажиглахад бусад бөө нарын нэгэн адил өргөн, дэрвэгэр, том хувцас өмссөн мэтээр дүрсэлжээ. Энэ нь хэмцэгийн хуягт бөө нарын гадна хэлбэр, тогтсон нэгэн загвартайг харуулж байна. Үүнийг судлаачид ажиглан хонх хэлбэрийн хүн, шувуу хүн, нөмрөгтөн гэх зэргээр нэрлэж ирсэн. Миний бие энэхүү хүн дүрст дүрийн гадна хэлбэр дүрслэлийг ажиглан эртний нүүдэлчдийн өмсөж байсан дах хэлбэрийн дээлний төрөл юм

болов уу гэж үзэж байна. Эртний адуучид нэгэн төрлийн дээл өмсдөг байсан ба үүнийг “аба” гэж нэрлэнэ. Аба гэдэг нь адууны арьс, /том баавгай мэтийн/ амьтаны арьсыг элдэж зөөлрүүлэн хоёр талыг нь ээлжлэн өмсөхөөр хийсэн, хүзүү, толгой гарах нүхтэй дээлийг нэрлэнэ. Өөрөөр хэлбэл нөмрөгтэй ижил төсөөтэй. Аба-д ханцуй байхгүй, шууд хүзүүгээр углан өмсдөг учраас гаднаас харахад дэрвэгэр харагддаг байжээ. Хуягт бөө нарын өмсөж байсан дээл хувцас нь хожим нэлээд хөгжсөн бөгөөд өд сөд, залаа, унжлага, манжлага хадсанаар баяжуулагджээ (Зураг-II, III). Анх хадны зураг дээрх шиг дэрвэгэр байсан бөгөөд одоо урт хормойтой, дэрвэгэр хэвээрээ байна. Их Ойгорын хадны зураг дахь хуягт бөө нарын биед өмсгөсөн хувцасыг бөөгийн хувцас гэмээр дүр төрхийг санагдуулж байна. Тухайлбал, хуягт бөө нарын цээж, бэлхүүс хэсгээр зэрэгцсэн олон гурвалжин дүрсэлсэн нь ямар нэгэн утга бэлгэдэлтэйгээс гадна, өнөөгийн бөө нарын хувцасны манжлага, унжлагатай их л төсөөтэй санагдана. Их Ойгорын нэгэн хуягт бөөгийн хувцасны хормойд доошоо унжуулсан “унжлага” цацаг дүрслэгдсэн нь бидний “хуяг өмссөн бөө” нар гэсэн саналыг илүүд баталгаажуулж байгаа мэт санагдана (Зураг-II, III). Хуягт бөө нарын их биед өөр олон “деталь” дүрслэлүүд байгаа бөгөөд цаашид нарийвчлан судлууштай.

Дүгнэлт

Улаанхус сумын 1 дүгээр багийн нутагт орших Их Ойгорын хадны зураг цаг хугацааны хувьд түрүү хүрлийн үе, хөгжингүй хүрэл зэвсгийн үеийг хамаарч байна. Энд хэдийгээр цөөн дүрслэл зурагдсан боловч, эрдэм шинжилгээ судалгааны өндөр ач холбогдолтой чухал дурсгал болно. Цаашид нарийвчилсан судалгаа шаардлагатай. Их Ойгорын хадны зураг дахь хэмцэгчүүдийн хуягт бөө нар нь түрүү хүрлийн бурхад буюу бөө нар болохыг тодруулахад маш их мэдээлэл агуулсан түүхэн дурсгал гэж үзэж байна.

Бид энэ удаад хуягт бөө нарын талаар ерөнхий дүр дүрслэлд товч авч үзэв. Цаашид өргөн хүрээнд авч үзэх, харьцуулсан судалгааг хийх нь дамжиггүй. Хуягт бөө нарын дүрслэл Монгол Алтайн хадны зурагт нэлээд олон удаа тохиолдож байгаа нь эртний Алтай нутгийн өвөр хэсэг хүн төрөлхтний амьдрах энергийн чухал төв байсныг, Хэмцэгчүүдийн ноёлох овог нүүдэллэн ирж хадны зураг урлаж, өөрсдийн түүхийг мөнхлөх завшаан байсныг харуулна. Хуягт бөө нарын ерөнхий хэлбэр маяг ижил боловч дүрслэл, зохиомжийн утга бэлгэдэл олон байгааг хуягт бөөд дүрслэгдсэн деталиудаас харж болно. Тиймээс хуягт бөө нар болон Их Ойгорын хадны зургийн судалгаа үргэлжлэлээ олно гэдэгт найдаж байна.

Ном зүй

Мөнхбаяр, 2010 – Ч.Мөнхбаяр. Хуурай салааны амны I чөмүрчөк булшны судалгааны эхний үр дүнгээс. // AVTA HISTORICA., Монгол Улсын Боловсролын Их Сургууль, tomus XI, -УБ., 2010:11

Өмирбек, 2011 – Б.Өмирбек. Үхрийн эвэр шүтлэгт нүүдэлчид. – Нүүдэлчдийн өв судлал. Tomus XI, Fasciculus 32.- УБ., 2011:63-70.

Өмирбек, 2016 – Б.Өмирбек. Хэмцэгийн хадны зураг. // Монгол Алтай сэтгүүл. -УБ., 2016:46-66

Өмирбек, 2019 – Б.Өмирбек. Баян-Өлгий аймгийн археологийн дурсгалууд.-УБ., 2019.

Өмирбек, 2013 – Б.Өмирбек. “Монгол Алтайн нурууны Хойд Хөлцөөтийн хадны зургийн судалгааны асуудалд”-2013. // Түүхийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл // гар бичмэл-УБ., 2013

Сэр-Оджав, 1958 – Н.Сэр-Оджав. Монголын баруун хэдэн аймагт явуулсан археологийн хайгуулын тухай. – Шинжлэх Ухаан Техник. - УБ., 1958:5-19.

Төрбат, 2019 – Ц.Төрбат. Хэмцэгийн соёлын хадны зураг.(2015 оны өгүүлэл) Археологийн судлал. Tomus XXXVIII, Fasciculus 1-11. -УБ., 2019

Төрбат нар, 2019 – Ц.Төрбат, Н.Батболд, Б.Өмирбек, Я.Бемманн.

Хэмцэгийн хадны зургийн судалгааны ангийн 2019 оны хээрийн шинжилгээний урьдчилсан үр дүн. “Монголын Археологи- 2019” ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2019 оны хээрийн судалгааны үр дүн.- УБ., 2019.

Цэвээндорж нар, 2019 – Д.Цэвээндорж, В.Д.Кубарев, Э.Якобсон. Шивээт хайрханы хадны зураг.-УБ., 2010.

Цэрэндагва, Далантай, 2021 – Я.Цэрэндагва, С.Далантай. “Нэн эртний хүний ул мөрийг алтай таван богдоос хайх цогц судалгаа” төслийн 2020 оны хээрийн шинжилгээний тайлан. - УБ., 2021. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан.




Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.



Их Оүзоп-I, II



Их Оүзоп-III, IV



Их Оүзоп-V



Их Оүзоп-VI



Их Ойгорын хадны зураг



Их Ойгор-I



Их Ойгор-II.



Их Ойгор-III, IV



Их Ойгор-VI